



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Богд сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2025/056/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор хот

2025 оны 02 дугаар сарын 20-ны өдөр

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын

Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат

Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер М.Алтантуяа

Утас: 70442424 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn

Аудитор Д.Эрдэнэбулган

Утас: 89818085 Цахим хаяг: erdenebulganda@audit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
Асуудлыг онцолсон хэсэг.....	3
Аудитын гол асуудал	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	7
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	14
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал.....	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.5.1 Завсрын аудитын талаар.....	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	19
5.1 Төлбөрийн акт	
5.2 Албан шаардлага	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг





**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2025.02.25 № 2/57

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Богд сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар тодорхой бус байдал нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

5020305

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>77,989,358.00</u>	<u>91,819,873.00</u>
33	АВЛАГА	12,000,000.00	12,688,593.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	11,993.00
335	Бусад авлага	12,000,000.00	12,676,600.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	676,600.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	12,000,000.00	12,000,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	65,989,358.00	79,131,280.00
354	Хангамжийн материал	61,629,358.00	74,771,280.00
35410	Бичиг хэргийн материал	7,735,975.00	6,388,875.00
35420	Аж ахуйн материал	53,893,383.00	68,382,405.00
35600	Мал амьтад	4,360,000.00	4,360,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,132,657,859.25</u>	<u>1,308,738,861.21</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,132,657,859.25	1,308,738,861.21
392	Биет хөрөнгө	1,119,069,859.25	1,239,297,305.69
39201	Барилга, байгууламж, орон сууц	807,546,824.84	856,769,824.84
39202	Хуримтлагдсан элэгдэл	-202,701,780.07	-254,564,577.16
39203	Авто-тээврийн хэрэгсэл	182,880,000.00	263,087,999.67
39204	Хуримтлагдсан элэгдэл	-91,520,833.60	-117,089,948.33
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	140,686,004.80	208,629,602.73
39206	Хуримтлагдсан элэгдэл	-102,396,847.76	-119,103,839.24
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	211,293,411.20	222,973,411.20
39208	Хуримтлагдсан элэгдэл	-102,060,230.36	-134,074,215.51
39209	Зам, гүүрийн байгууламж	449,472,031.00	449,472,031.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-226,849,646.30	-249,258,493.58
39214	Бусад үндсэн хөрөнгө	219,725,700.00	303,610,486.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-167,304,774.50	-191,454,975.93
39217	Ном	300,000.00	300,000.00
393	Биет бус хөрөнгө	13,588,000.00	69,441,555.52
39301	Програм хангамж	559,000.00	559,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-559,000.00	-559,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	13,588,000.00	69,886,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-444,444.48
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,210,647,217.25</u>	<u>1,400,558,734.21</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>433,508.00</u>	<u>00.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	433,508.00	00.00
413	Өглөг	433,508.00	00.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	133,508.00	00.00
4136	Бусад өглөг	300,000.00	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	300,000.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,210,213,709.25</u>	<u>1,400,558,734.21</u>

51	Засгийн газрын хувь оролцоо	1,210,213,709.25	1,400,558,734.21
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	474,836,479.36	474,836,479.36
51101	Өмч: - төрийн	474,836,479.36	474,836,479.36
512	Хуримтлагдсан үр дүн	577,949,835.34	768,294,860.30
51210	Өмнөх үеийн үр дүн	577,949,835.34	577,949,835.34
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	190,345,024.96
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	157,427,394.55	157,427,394.55
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,210,647,217.25	1,400,558,734.21

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,038,840,492.00	1,559,019,189.10
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	336,559,275.00	422,256,883.60
120	Нийтлэг татварын бус орлого	336,559,275.00	422,256,883.60
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	128,940.00	705,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	128,940.00	705,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	702,281,217.00	1,136,762,305.50
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	55,265,817.00	55,447,005.50
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	826,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	55,265,817.00	54,620,505.50
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	647,015,400.00	1,081,315,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	647,015,400.00	1,081,315,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	790,465,556.89	1,368,674,164.14
21	УРСГАЛ ЗАРДАЛ	777,965,556.65	1,368,674,164.14
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	770,962,158.69	1,286,611,701.88
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	393,269,681.59	649,342,688.80
210101	Үндсэн цалин	291,963,168.90	396,328,829.79
210102	Нэмэгдэл	84,313,303.09	227,042,459.01
210104	Урамшуулал	16,993,209.60	25,971,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,308,251.09	80,825,323.44
210201	Тэтгэврийн даатгал	34,850,514.49	55,040,942.91
210202	Тэтгэмжийн даатгал	3,932,696.75	6,354,350.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,952,994.10	3,312,211.00
210204	Ажилгүйдлийн даатгал	928,038.81	3,164,187.50
210205	Эрүүл мэндийн даатгал	7,644,006.94	12,953,632.03
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,900,481.36	29,236,203.00
210301	Гэрэл, цахилгаан	5,772,680.00	7,471,655.00
210302	Түлш, халаалт	17,127,801.36	20,764,548.00
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	1,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	78,255,047.00	93,699,243.00

210401	Бичиг хэрэг	9,019,500.00	13,551,550.00
210402	Тээвэр, шатахуун	40,036,585.00	37,300,010.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,256,000.00	1,069,200.00
210404	Ном, хэвлэл	300,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	12,780,362.00	22,641,852.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,862,600.00	19,136,631.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,937,000.00	22,769,650.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	139,000.00	7,357,900.00
210602	Тавилга	00.00	2,792,150.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	3,200,000.00
210604	Урсгал засвар	8,798,000.00	9,419,600.00
2107	Томилолт, зочны зардал	8,908,000.00	9,576,308.00
210702	Дотоод албан томилолт	8,908,000.00	9,576,308.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	62,877,848.00	180,702,108.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	57,915,750.00	175,151,656.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	800,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	762,724.00	614,326.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,123,653.00	590,668.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	132,000.00	215,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,415,200.00	3,009,600.00
210807	Газрын төлбөр	1,528,521.00	320,758.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	144,505,849.65	220,460,177.64
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	38,363,920.00	40,786,296.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,767,000.00	6,517,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	104,374,929.65	173,156,381.64
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,003,397.96	82,062,462.26
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,240,000.00	20,902,766.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	16,377,766.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,240,000.00	4,525,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,763,397.96	61,159,696.26
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,745,500.96	61,159,696.26
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	12,500,000.24	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	12,500,000.24	00.00
225101	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз) /ТӨҮГ/	12,500,000.24	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	248,374,935.11	190,345,024.96
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	248,374,935.11	190,345,024.96



2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	702,410,157.00	1,137,467,305.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	128,940.00	705,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	128,940.00	705,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	128,940.00	705,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	128,940.00	705,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	702,281,217.00	1,136,762,305.50
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	55,265,817.00	55,447,005.50
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	826,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	55,265,817.00	54,620,505.50
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	647,015,400.00	1,081,315,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	647,015,400.00	1,081,315,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	681,112,857.00	1,101,824,405.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	681,112,857.00	1,101,824,405.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	673,759,459.04	1,019,761,943.24
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	394,982,738.17	649,186,214.80
210101	Үндсэн цалин	271,250,831.01	382,477,612.22
210102	Нэмэгдэл	123,731,907.16	240,975,911.08
210104	Урамшуулал	00.00	25,732,691.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,595,194.51	80,837,316.44
210201	Тэтгэврийн даатгал	33,109,212.90	55,052,935.91
210202	Тэтгэмжийн даатгал	3,924,657.31	6,354,350.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,143,102.02	3,312,211.00
210204	Ажилгүйдлийн даатгал	739,764.01	3,164,187.50
210205	Эрүүл мэндийн даатгал	7,678,458.27	12,953,632.03
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,586,761.36	29,813,423.00
210301	Гэрэл, цахилгаан	5,206,929.36	7,471,655.00
210302	Түлш, халаалт	17,379,832.00	21,341,768.00
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	1,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	66,306,147.00	77,354,146.00
210401	Бичиг хэрэг	8,706,680.00	9,866,250.00
210402	Тээвэр, шатахуун	36,890,605.00	32,480,770.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,810,600.00	1,807,600.00
210404	Ном, хэвлэл	300,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	13,693,662.00	27,460,926.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,904,600.00	5,738,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,139,000.00	11,797,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	115,500.00	698,700.00

210604	Урсгал засвар	13,023,500.00	11,098,700.00
2107	Томилолт, зочны зардал	8,558,000.00	9,182,600.00
210702	Дотоод албан томилолт	8,558,000.00	9,182,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	73,692,698.00	106,514,731.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	67,230,200.00	101,099,279.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	800,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	762,724.00	614,326.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,123,653.00	587,668.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	132,000.00	218,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,915,600.00	3,009,600.00
210807	Газрын төлбөр	1,528,521.00	185,758.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	44,898,920.00	55,076,112.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	43,205,920.00	47,124,712.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,693,000.00	7,951,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,353,397.96	82,062,462.26
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,590,000.00	20,902,766.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	16,377,766.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,590,000.00	4,525,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,763,397.96	61,159,696.26
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,745,500.96	61,159,696.26
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	21,297,300.00	35,642,900.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	21,297,300.00	35,642,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	21,297,300.00	35,642,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	21,297,300.00	35,642,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	21,297,300.00	35,642,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-21,297,300.00	-35,642,900.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	474,836,479.36	157,427,394.55	317,574,900.23	00.00	949,838,774.14
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	12,000,000.00	00.00	12,000,000.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	474,836,479.36	157,427,394.55	329,574,900.23	00.00	961,838,774.14
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	248,374,935.11	00.00	248,374,935.11

C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	474,836,479.36	157,427,394.55	577,949,835.34	00.00	1,210,213,709.25
D01	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	474,836,479.36	157,427,394.55	577,949,835.34	00.00	1,210,213,709.25
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	474,836,479.36	157,427,394.55	577,949,835.34	00.00	1,210,213,709.25
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	190,345,024.96	00.00	190,345,024.96
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	474,836,479.36	157,427,394.55	768,294,860.30	00.00	1,400,558,734.21

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,080,165,300.00	1,022,141,950.00	58,391,173.76	94.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,080,165,300.00	1,022,141,950.00	58,391,173.76	94.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,075,565,300.00	1,017,249,126.24	58,316,173.76	94.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	681,537,500.00	649,186,214.80	32,351,285.20	95.2
210101	Үндсэн цалин	377,539,200.00	382,477,612.22	-4,938,412.22	130
210102	Нэмэгдэл	281,596,200.00	240,975,911.08	40,620,288.92	85.5
210104	Урамшуулал	22,402,100.00	25,732,691.50	-3,330,591.50	114
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	85,192,300.00	80,837,316.44	4,354,983.56	94.8
210201	Тэтгэврийн даатгал	57,930,800.00	55,052,935.91	2,877,864.09	95
210202	Тэтгэмжийн даатгал	6,815,300.00	6,354,350.00	460,950.00	93.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,407,700.00	3,312,211.00	95,489.00	97.1
210204	Ажилгүйдлийн даатгал	3,407,700.00	3,164,187.50	243,512.50	92.8
210205	Эрүүл мэндийн даатгал	13,630,800.00	12,953,632.03	677,167.97	95
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,637,000.00	29,813,423.00	4,823,577.00	86
210301	Гэрэл, цахилгаан	8,590,000.00	7,471,655.00	1,118,345.00	86.9
210302	Түлш, халаалт	25,047,000.00	21,341,768.00	3,705,232.00	85.2
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	1,000,000.00	0.00	100
2104	Хангамж, бараа материалын зардал	75,977,600.00	77,354,146.00	-1,376,546.00	96.6
210401	Бичиг хэрэг	9,506,600.00	9,866,250.00	-359,650.00	103
210402	Тээвэр, шатахуун	33,600,000.00	32,480,770.00	1,119,230.00	96.6
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,470,300.00	1,807,600.00	-337,300.00	122
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	25,900,700.00	27,460,926.00	-1,560,226.00	106
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,500,000.00	5,738,600.00	-238,600.00	104
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	32,320,000.00	32,320,000.00	0.00	100
210601	Багаж, техник, хэрэгсэл	12,500,000.00	12,210,300.00	289,700.00	97.6

210602	Тавилга	9,000,000.00	9,011,000.00	-11,000.00	100
210604	Урсгал засвар	10,820,000.00	11,098,700.00	-278,700.00	102
2107	Томилолт, зочны зардал	9,467,700.00	9,182,600.00	285,100.00	96.9
210702	Дотоод албан томилолт	9,467,700.00	9,182,600.00	285,100.00	96.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	103,224,500.00	85,669,856.00	17,554,644.00	82.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	96,373,500.00	80,254,404.00	16,119,096.00	83.2
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	800,000.00	800,000.00	0.00	100
210803	Даатгалын үйлчилгээ	800,000.00	614,326.00	185,674.00	76.7
210804	Тээврийн хэрэгслийн татвар	827,000.00	587,668.00	239,332.00	71.1
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	360,000.00	218,100.00	141,900.00	60.5
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,564,000.00	3,009,600.00	554,400.00	84.4
210807	Газрын төлбөр	500,000.00	185,758.00	314,242.00	37.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	53208700.00	52885570.00	323,130.00	99.3
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	45,208,700.00	44,934,170.00	274,530.00	99.3
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,000,000.00	7,951,400.00	48,600.00	99.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4600000.00	4525000.00	75,000.00	98.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,600,000.00	4,525,000.00	75,000.00	98.3
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,600,000.00	4,525,000.00	75,000.00	98.3
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	922,882,400.00	1,082,783,581.00	-159,901,181.00	117.3
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	921,882,400.00	1,081,315,300.00	-159,432,900.00	117.3
132001	Орон нутгийн төсвөөс	921,882,400.00	1,081,315,300.00	-159,432,900.00	117.3
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,000,000.00	705,000.00	295,000.00	70.5
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	705,000.00	-705,000.00	
3	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00	00.00	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00	00.00	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	22.00	22.00	0.00	
620001	Удирдах ажилтан	03.00	03.00	0.00	
620002	Гүйцэтгэх ажилтан	18.00	18.00	0.00	
620003	Үйлчлэх ажилтан	01.00	01.00	0.00	



2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	55,265.8	39,315.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	55,265.8	39,315.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	55,265.8	39,315.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	55,247.9	22,787.4
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	55,247.9	22,787.4
213208	Хөдөө орон нутгийн тэтгэмж	0.00	16,377.7
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	17.9	150.2
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	0.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	0.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	55,265.8	39,315.3
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Богд сумын Засаг даргын Тамгын газар нь "Хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрх, чиг үүргийг хэрэгжүүлж сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх бодлогыг зүй зохистой тодорхойлон түүнийг хэрэгжүүлэхэд сумын иргэдийн бүтээлч, санаачилга, идэвхтэй оролцоог нэмэгдүүлэх, орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллагуулын үйл ажиллагааг дэмжин хамтран иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг ойртуулах, тэдний язгуур, эрх ашгийг дээдлэн төрийн захиргааны байгууллагыг чадварлаг, нээлттэй ил тод болгон төлөвшүүлж иргэн, нийгмийн хөгжлийн асуудлыг бие даан шийдвэрлэх, ард түмний аж амьдралыг дээшлүүлж ая тухтай ажиллаж амьдрах нөхцөл бүрдүүлэх" эрхэм зорилготой тус байгууллага нь удирдах 1, гүйцэтгэх ажилтан 18, үйлчлэх ажилтан 1 нийт 22 орон тоотой үйл ажиллагаа явуулсан байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг дарга Б.Бурмаа, 2 дугаар гарын үсгийг 2024 оны 11 дүгээр сарын 20-ыг хүртэл нягтлан бодогч Ч.Долгорсүрэн, 2024 оны 11 дүгээр сарын 29-ны өдрөөс З.Нанжидмаа нар зурж, нярав Ц.Туяа ажиллажээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Мэдээллийн ил тод байдлын тухай, Шилэн дансны тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Байгууллагын нууцын тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Гамшгаас хамгаалах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Зөрчлийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Архивын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай болон Татварын багц хуулиудыг мөрдөж үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг үргэлжлүүлэн мөрдсөн;
- Засгийн газрын тогтоолоор албан хаагчдын цалин нэмэгдсэн;
- ТБОНӨХБАҮХАТХ-ийн шинэчилсэн найруулгыг 2023.06.16-ны өдөр баталж, 2024.01.01-ний өдрөөс эхлэн мөрдсөн;
- Сангийн сайдын 2024 оны 2024 оны 229, А/211 дугаар тушаалаар Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам, төсвийн эдийн засгийн ангилал, санхүүгийн байдлын тайлангийн дансны жагсаалтыг шинэчлэн баталсан.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авсан ба дотоод аудит гүйцэтгээгүй тул аудитад ашиглах баримт материал байхгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Богд сумын Засаг даргын Тамгын газар нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж буй Баянхонгор аймгийн СТСХ-ээс бэлтгэж гаргасан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Богд сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайланг УСНББОУС-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 189,899.5 мянган төгрөгөөр буюу 86.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт (мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	-	0
Авлага	12,000.0	12,688.5.0	687.9
Бараа материал	65,989.3	79,131.2	13,141.9
Үндсэн хөрөнгө	1,132,657.8	1,308,738.8	176,081.0
Хуримтлагдсан элэгдэл	-104,374.9	-173,156.3	-68,781.4
Нийт хөрөнгө	1,210,647.2	1,400,558.7	189,911.5
Өр төлбөр	433.5	-	-433.5
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,210,213.7	1,400,558.7	189,911.5
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,210,647.2	1,400,558.7	189,911.5

Эх сурвалж: Богд сумын Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайлан

Дээрх хүснэгтээс харахад Богд сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан дансад нь авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, Засгийн газрын хувь оролцоо данс байна.

Оны эцэст тус байгууллага нийгмийн даатгалын шимтгэлийн авлагатай гарсан байхад санхүүгийн тайланд авлагыг тусгаагүй байсан зөрчил аудитаар илэрч, санхүүгийн тайланд 11.2 мянган төгрөгийн авлагыг нэмэгдүүлэн аудитлав.

Бараа материалын оны эцсийн үлдэгдэл өмнөх оноос 13,141.9 мянган төгрөгөөр өсч, 79,131.2 мянган төгрөг болсон нь тайлант оны зардлаас 11,897.9 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 55,972.9 мянган төгрөгийн аж ахуйн материал, 48,899.8 мянган төгрөгийн түлш шатах тослох материал, 8,200.0 мянган төгрөгний бусад хангамжийн материал, шилжүүлэн авсан 22,181.4 мянган төгрөгийн аж ахуйн материал, 85,776.0 мянган төгрөгийн бусад хангамжийн материалыг орлогыг авч, 13,245.0 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 63,665.2 мянган төгрөгийн аж ахуйн материал, 48,899.8 мянган төгрөгийн түлш шатах тослох материал, 93,976.0 мянган төгрөгийн бусад хангамжийн материал зарцуулсантай холбоотой байна.

Богд сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгө өмнөх оноос 176,081.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант жилийн зардлаас 3,500.0 мянган төгрөгийн авто тээврийн хэрэгсэл, 20,462.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 11,680.0 мянган төгрөгийн тавилга хэрэгсэл, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргын 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 99 дүгээр захирамж, сумын ИТХ-ын хуралдааны 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 3/14 дүгээр тогтоолын дагуу 49,223.0 мянган төгрөгийн барилга байгууламж, 76,707.9 мянган төгрөгийн авто тээврийн хэрэгсэл, 47,480.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 83,884.7 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгийг шилжүүлэн авч, 56,298.0 мянган төгрөгийн бусад биет бус хөрөнгө бүртгэсэнтэй холбоотой байна.

Тайлант онд Засаг даргын нөөц хөрөнгийн зардалд 40,000.0 мянган төгрөгийг төлөвлөснөөс 11,100.0 мянган төгрөгийг өвс тэжээлийн тээвэрлэлтийн зардалд, 650.0 мянган төгрөгийг цэрэг татлагын зардалд, 1,288.4 мянган төгрөгийг хээрийн бэлтгэл хангах зардалд, 26,961.6 мянган төгрөгийг нэг удаагийн шинжтэй арга хэмжээнд зарцуулсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 887,970.5 мянга, нийт зарлагыг 887,970.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас улсын төсвөөс авах санхүүжилтийг 173,869.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 1,061,839.0 мянган төгрөгөөр баталсан нь цалингийн зардал, бараа материалын зардлыг нэмж баталснаас шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 20,476.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгож, 1,082,315.9 мянган төгрөгөөр баталсан нь Засгийн газрын тогтоолоор цалин нэмэгдсэн,

хангамж, бараа материалын зардал, томилолтын зардлуудыг нэмэгдүүлэн баталсантай холбоотой байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс авах санхүүжилтийг 1,082,315.9 мянган төгрөгөөр бүрэн авч, зардлын гүйцэтгэл 1,022,141.9 мянган төгрөг буюу төлөвлөсөн зардлын 94.5 хувьтай байсан, оны эцэст зардлын хэмнэлтийн 61,159.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 3. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл (мянган төгрөгөөр)

№	Хөтөлбөр арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	729,328.5	710,466.4	18,862.1	97.4
2	80106 Баг, хорооны үйл ажиллагааны зардал	193,553.9	167,558.8	25,995.1	86.5
3	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	4,000.0	3,925.0	75.0	100
4	81102 Орон нутгийн нөөц хөрөнгө	40,000.0	39,951.1	48.9	100
5	81701 Байгаль орчны хамгаалах нөхөн сэргээх зардал	83,133.5	69,053.4	14,080.1	83.6
6	82212 Хог хаягдлын зардал	26,800.0	26,203.9	596.2	97.7
7	82310 Гамшигаас сэргийлэх	3,500.0	2,990.0	501.0	85.4
8	81549 Ахмадын сан	2,000.0	1,993.0		99.6
	дүн	1,082,315.9	1,022,141.9	60,174.0	94.4

Эх сурвалж: Богд сумын Засаг даргын Тамгын газрын төсвийн гүйцэтгэлийн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар 39,315.3 мянган төгрөг орсноос хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж 16,377.7 мянган төгрөгийг, өвс тэжээлийн үнэ 22,787.4 мянган төгрөгийг шилжүүлж, 150.2 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Богд сумын Засаг даргын Тамгын газар нь 2024 онд БХАБСЗДТГ/2024/0202019 түлш шатах тослох материалын тендерийг харьцуулалтын аргаар зарласан байна. Тендерт Жаргалант богд ХХК компаний баримт бичиг шалгарч 28,000.0 мянган төгрөгний гэрээ байгуулсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Богд сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний

өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, хууль тогтоомжийн хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Эрдэнэбулган гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Богд сумын Засаг даргын Тамгын газар нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 1/723 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант жилийн батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлж, материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны батлагдсан төсвийн 1,082,315.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 10,823.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 7,035.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуульд хамаарах асуудал байхгүй бөгөөд тогтмол зардлыг 100 хувь зарцуулсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Богд сумын Засаг даргын Тамгын газар нь 2024 оны мэдээллээс 18,813.1 мянган төгрөгийн орлогын гүйлгээг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлээгүй зөрчил илэрсэн.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим мэдээлэлд орлогын мэдээллийг нөхөж байршуулах албан шаардлага өгсөн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус байгууллагад завсрын аудитыг гүйцэтгээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитыг "Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар"-ын ахлах аудитор М.Алтантуяа гүйцэтгэж, "Хязгаарлалттай" дүгнэлт өгч, аудитын тайлангаар 5,426.0 мянган төгрөгийн 5 шийдвэрийг өгсөн, хэрэгжилтийг санхүүгийн тайлангийн FAS системд оруулж, албан бичгээр хариуг ирүүлж, бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт (мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	3	1,826.0	3	1,826.0	100
Албан шаардлага	2	3,600.0	2	3,600.0	100
Нийт дүн	5	5,426.0	5	5,426.0	100

Эх сурвалж: Санхүүгийн тайлангийн FAS систем, ирүүлсэн холбогдох баримт, материал

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитаар анхаарал татсан асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 4,213.2 мянган төгрөгийн 2 алдаа¹ илэрснээс аудитын явцад авлага, бараа материалын тайланд алдааг залруулав.

Залруулсан алдаа:

1. Нийгмийн даатгалын шимтгэлийн 11.9 мянган төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй байгаа нь Иж бүрэн байх, Эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй авлагыг нэмэгдүүлж залруулсан.

2. Байгууллагын нярав тайлант онд зарцуулсан 48,899.8 мянган төгрөгийн шатахууны тайланг 1,350.0 мянган төгрөгөөр илүү орлого авсан, 63,665.2 сая төгрөгийн аж ахуйн материалын тайланг 2.851.3 мянган төгрөгөөр илүү зарцуулан тайлагнасан байхад байгууллагын нягтлан бодогч хяналт тавьж ажиллаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалт үнэн зөв байх заалтыг хангахгүй тул бараа материалын тайланг залруулсан.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлийн дүн 4,213.2 мянган төгрөг нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

5.1 Албан шаардлага

Богд сумын Засаг даргын Тамгын газар нь шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 18,813.0 мянган төгрөгийн орлогын гүйлгээг мэдээлээгүй зөрчил илэрсэн.

Энэ нь Төрийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дахь “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, Төрийн аудитын тухай хуулийн 42, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын байгууллагаас өгсөн зөвлөмж, албан шаардлагыг бүрэн биелүүлж зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

Дээрх албан шаардлагын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 04 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан нягтлан бодогчид талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл (мянган төгрөгөөр)

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Нийгмийн даатгалын шимтгэлийн 11.9 мянган төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтыг зөрчсөн байна.	1	11.9					1	11.9				
Байгууллагын нярав 2024 оны шатахууны тайлангийн орлогыг илүү, аж ахуйн тайлангийн зарцуулалтыг илүү тайлагнасан байхад байгууллагын нягтлан бодогч хяналт тавьж ажиллаагүй байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх заалтыг зөрчсөн байна.	1	4,201.3					1	4,201.3				
Дүн	2	4,213.2	0	0	0	0	2	4,213.2	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл (мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 18,813.0 мянган төгрөгийн орлогын гүйлгээг мэдээлээгүй. Энэ нь Төрийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дахь "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", Төрийн аудитын тухай хуулийн 42, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийг зөрчсөн байна.	1	18,813.0			1	18,813.0							
Дүн	1	18,813.0			1	18,813.0	0	-	0		0	0	0

---oOo---

